

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/57/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойр хот
2022 он

Дарга тэргүүлэх аудитор:
Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 7054-3179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор:
Утас: 7054-3179 Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	17
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.6.3 Нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГСА	Говьсүмбэр аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

᠑᠐᠒᠒.᠐᠗.2᠘ № 45

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтал сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянтал сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баянтал сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 63,620.5 мянган төгрөгийн дараах алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 61,746.7 мянган төгрөгөөр их байна.

1. Завсрын болон өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. санхүүгийн ажилтнууд 4 удаа солигдсоноос үндсэн хөрөнгө, бараа материалын тайланд хяналт тавьж баталгаажуулаагүй, ажил гүйлгээг гарсан тухай бүрд хөдөлгөөнийг бүртгээгүй, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж тайлагнасан. Бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл 2,722.4 мянга, орлого 7,273.6 мянга, зарлага 5,196.7 мянга, үлдэгдэл 4,799.7 мянга, нийт 19,992.8 мянган төгрөгөөр зөрүүтэй, байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 2,705.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан.
2. Ажиллагсдад 40,922.0 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг бодож олгохдоо тухайн сарын төсөвт багтах дүнг тухайн сард нь олгож, дутуу олгосон илүү цагийн цалинг дараа сард олгох зэргээр нягтлан бодох

018020135

бүртгэлийг аккурэл сууриар бус мөнгөн сууриар хөтөлсөн зөрчлүүд нь аудитын дүгнэлтийг өөрчлөх гол шалтгаан болсон.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 14 дүгээр зүйлийн 14.4.7, 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1 дах заалтуудыг зөрчсөн, УСНББОУС-1(15,16), УСНББОУС-1(7), УСНББОУС-12(476,49), УСНББОУС-33(29), санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,387,654.78	176,481,578.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	2,806,492.89
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	2,806,492.89
31210	Төгрөг	0	2,806,492.89
31211	Төрийн сангийн харилцах	0	1,994,006.32
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0	812,486.57
33	АВЛАГА	1,739,687.11	135,361,105.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,142,232.81	991,651.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0	133,772,000.00
33500	Бусад авлага	597,454.30	597,454.30
33520	Хувь хүмүүсээс авах авлага	597,454.30	597,454.30
34	УРЬДЧИЛГАА	3,991,362.00	3,991,362.00
34710	Урьдчилгаа тооцоо	3,991,362.00	3,991,362.00
34713	Цалингийн урьдчилгаа	3,991,362.00	3,991,362.00
35	БАРАА МАТЕРИАЛ	60,656,605.67	34,322,618.00
35100	Түүхий эд материал	52,627,101.17	30,999,188.50
35110	Тусгай зориулалттай материал	30,334,035.88	14,138,650.00
35130	Эм боох материал	22,293,065.29	16,860,538.50
35400	Хангамжийн материал	8,029,504.50	3,323,429.50
35410	Бичиг хэргийн материал	615,000.00	48,000.00
35420	Аж ахуйн материал	1,330,050.00	927,300.00
35440	Түлш, шатах тослох материал	3,705,000.00	372,020.00
35460	Хүнсний материал	2,379,454.50	1,976,109.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	377,200,574.85	406,098,767.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	377,200,574.85	406,098,767.33
39200	Биет хөрөнгө	367,200,574.85	396,098,767.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	335,060,548.71	335,060,548.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	-17,627,618.46	-24,524,761.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	64,040,000.00	64,040,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-36,462,499.92	-42,009,166.56
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	70,243,922.05	112,280,459.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-50,794,303.28	-57,343,066.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,394,138.20	18,323,445.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,653,612.45	-9,728,692.09
39300	Биет бус хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	443,588,229.63	582,580,345.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,076,034.48	3,721,850.98
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,076,034.48	3,721,850.98
41300	Өглөг	1,076,034.48	3,721,850.98
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	802,883.38	2,660,432.72
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	228,154.00	228,152.16
41360	Бусад өглөг	44,997.10	833,266.10
41361	Байгууллагад төлөх өглөг	0	331,450.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	44,997.10	501,816.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	442,512,195.15	578,858,494.54
51	Засгийн газрын хувь оролцоо	442,512,195.15	578,858,494.54

Баянтал сумын Эрүүл төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	523,404,676.25	523,404,676.25
51200	Хуримтлагдсан үр дүн	-85,518,450.42	50,827,848.97
51210	Өмнөх үеийн үр дүн	-123,684,286.72	-85,518,450.42
51220	Тайлант үеийн үр дүн	38,165,836.30	136,346,299.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,625,969.32	4,625,969.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	443,588,229.63	582,580,345.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	412,926,515.14	690,453,055.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,252,705.14	127,411,715.96
120	Нийтлэг татварын бус орлого	65,252,705.14	127,411,715.96
120003	Торгуулийн орлого	0	147,429.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	31,500,000.00	46,165,944.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	33,752,705.14	81,098,342.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	347,673,810.00	563,041,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	277,095,400.00	279,003,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	277,095,400.00	279,003,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,357,800.00	221,549,060.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000.00	221,549,060.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	357,800.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,800,000.00	49,037,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,800,000.00	49,037,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,420,610.00	13,451,480.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,420,610.00	13,451,480.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	374,760,678.84	554,106,756.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	374,760,678.84	554,106,756.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,200,035.67	529,793,156.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,768,997.83	250,139,975.23
210101	Үндсэн цалин	208,768,997.83	250,139,975.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,814,872.16	32,395,883.00
210201	Тэтгэврийн даатгал	17,359,448.43	23,380,980.02
210202	Тэтгэмжийн даатгал	2,042,288.05	3,542,567.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,633,830.44	1,502,320.94
210204	Ажилгүйдлийн даатгал	343,573.20	1,108,966.20
210205	Эрүүл мэндийн даатгал	3,435,732.04	2,861,048.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,539,451.06	47,756,655.81
210301	Гэрэл, цахилгаан	1,816,075.06	2,010,281.81
210302	Түлш, халаалт	37,878,764.00	42,025,382.00
210303	Цэвэр, бохир ус	3,844,612.00	3,720,992.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,219,078.94	54,007,898.88
210401	Бичиг хэрэг	2,326,200.00	4,001,400.00
210402	Тээвэр, шатахуун	10,203,151.94	19,152,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	766,100.00	2,124,200.00

Баянтал сумын Эрүүл төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	512,400.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	296,000.00	6,986,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,140,750.00	0
210408	Бараа материал акталсны зардал	0	21,142,718.88
210409	Бараа материал шилжүүлсний зардал	1,974,477.00	0
2105	Нормативт зардал	37,269,462.27	118,785,111.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,481,723.07	111,112,250.57
210502	Хоол, хүнс	4,572,439.20	7,672,861.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	215,300.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,686,800.00	4,713,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	501,000.00	0
210604	Урсгал засвар	2,185,800.00	4,713,300.00
2107	Томилолт, зочны зардал	573,000.00	865,920.00
210702	Дотоод албан томилолт	573,000.00	865,920.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	456,125.00	478,960.00
210803	Даатгалын үйлчилгээ	66,825.00	210,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,300.00	99,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	120,000.00
210807	Газрын төлбөр	97,000.00	49,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,872,248.41	20,649,452.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,524,830.00	581,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,347,418.41	20,067,652.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,560,643.17	24,313,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,033,500.00	24,313,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	17,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,033,500.00	6,913,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,260,548.94	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,260,548.94	0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,266,594.23	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,266,594.23	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	38,165,836.30	136,346,299.39
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	38,165,836.30	136,346,299.39

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	523,404,676.25	4,625,969.32	-123,684,286.72	404,346,358.85
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	523,404,676.25	4,625,969.32	-123,684,286.72	404,346,358.85
4	Тайлант үеийн үр дүн	0	0	38,165,836.30	38,165,836.30
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	523,404,676.25	4,625,969.32	-85,518,450.42	442,512,195.15
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	523,404,676.25	4,625,969.32	-85,518,450.42	442,512,195.15
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	523,404,676.25	4,625,969.32	-85,518,450.42	442,512,195.15
8	Тайлант үеийн үр дүн	0	0	136,346,299.39	136,346,299.39
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	523,404,676.25	4,625,969.32	50,827,848.97	578,858,494.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	347,673,810.00	429,269,340.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	347,673,810.00	429,269,340.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	277,095,400.00	279,003,200.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	277,095,400.00	279,003,200.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,357,800.00	87,777,060.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000.00	87,777,060.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	357,800.00	0	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,800,000.00	49,037,600.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,800,000.00	49,037,600.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,420,610.00	13,451,480.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,420,610.00	13,451,480.00	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	342,783,710.00	423,662,947.11	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342,783,710.00	423,662,947.11	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	329,223,066.83	399,349,347.11	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,481,062.15	247,763,563.61	
210101	Үндсэн цалин	174,623,176.15	124,997,936.69	
210102	Нэмэгдэл	30,138,852.50	109,752,575.11	
210104	Урамшуулал	3,719,033.50	13,013,051.81	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,164,999.07	31,828,465.47	
210201	Тэтгэврийн даатгал	22,898,993.08	23,237,162.32	
210202	Тэтгэмжийн даатгал	611,704.19	2,401,175.20	
210203	ҮОМШӨ-ний даатгал	489,363.36	1,920,940.14	
210204	Ажилгүйдлийн даатгал	105,903.50	388,107.99	
210205	Эрүүл мэндийн даатгал	1,059,034.94	3,881,079.82	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,539,451.06	47,756,655.81	
210301	Гэрэл, цахилгаан	1,816,075.06	2,010,281.81	
210302	Түлш, халаалт	38,320,040.00	42,025,382.00	
210303	Цэвэр, бохир ус	3,403,336.00	3,720,992.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	19,152,500.00	26,364,000.00	
210401	Бичиг хэрэг	2,579,100.00	3,479,400.00	
210402	Тээвэр, шатахуун	14,538,900.00	15,820,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	766,100.00	2,124,200.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	507,400.00	600,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	761,000.00	4,340,400.00	
2105	Нормативт зардал	23,934,999.55	35,303,532.22	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,708,499.55	26,833,610.22	
210502	Хоол, хүнс	6,118,100.00	8,469,922.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,108,400.00	0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,278,000.00	7,333,250.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,231,500.00	500,000.00	
210604	Урсгал засвар	2,046,500.00	6,833,250.00	
2107	Томилолт, зочны зардал	573,000.00	865,920.00	
210702	Дотоод албан томилолт	573,000.00	865,920.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	826,725.00	478,960.00	
210803	Даатгалын үйлчилгээ	66,825.00	210,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,300.00	99,000.00	

Баянтал сумын Эрүүл төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	590,600.00	120,000.00
210807	Газрын төлбөр	97,000.00	49,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,272,330.00	1,655,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,272,330.00	1,655,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,560,643.17	24,313,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,033,500.00	24,313,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	17,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,033,500.00	6,913,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,260,548.94	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,260,548.94	0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,266,594.23	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,266,594.23	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,890,100.00	5,606,392.89
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,890,100.00	2,799,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,890,100.00	2,799,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,890,100.00	2,799,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,890,100.00	2,799,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,890,100.00	-2,799,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	2,806,492.89
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	2,806,492.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	347,839,900.00	339,498,273.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,839,900.00	339,498,273.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,000,300.00	338,698,273.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,241,700.00	232,238,563.61
210101	Үндсэн цалин	141,506,000.00	109,644,049.93
210102	Нэмэгдэл	69,301,200.00	109,581,461.87
210104	Урамшуулал	21,434,500.00	13,013,051.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,257,400.00	30,156,140.07
210201	Тэтгэврийн даатгал	22,697,000.00	21,564,836.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,390,400.00	2,401,175.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,911,600.00	1,920,940.14
210204	Ажилгүйдлийн даатгал	478,800.00	388,107.99
210205	Эрүүл мэндийн даатгал	4,779,600.00	3,881,079.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,704,300.00	47,704,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,600,000.00	2,010,281.81
210302	Түлш, халаалт	40,904,300.00	41,973,026.19
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	3,720,992.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,014,000.00	13,014,000.00
210401	Бичиг хэрэг	1,884,000.00	2,489,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,730,000.00	5,820,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	2,124,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	960,000.00	2,340,400.00
2105	Нормативт зардал	19,900,000.00	13,856,970.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,600,000.00	10,524,670.00
210502	Хоол, хүнс	6,300,000.00	3,332,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,333,300.00	467,380.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	0
210604	Урсгал засвар	1,333,300.00	467,380.00
2107	Томилолт, зочны зардал	0	865,920.00
210702	Дотоод албан томилолт	0	865,920.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	549,600.00	395,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	210,000.00	210,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,100.00	65,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,500.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	839,600.00	800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	839,600.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	839,600.00	800,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	347,839,900.00	341,492,280.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	279,003,200.00	279,003,200.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	279,003,200.00	279,003,200.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,037,600.00	49,037,600.00
320001	Орон нутгийн төсвөөс	49,037,600.00	49,037,600.00

Баянтал сумын Эрүүл төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,799,100.00	13,451,480.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,799,100.00	13,451,480.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	1,994,006.32
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	15
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	13	11
620003	Гэрээт ажилтан	3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,964.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,450.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,450.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,525.00
210101	Үндсэн цалин	15,353.89
210102	Нэмэгдэл	171.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,672.33
210201	Тэтгэврийн даатгал	1,672.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52.36
210302	Түлш, халаалт	52.36
2104	Хангамж, бараа материалын зардал	13,350.00
210401	Бичиг хэрэг	990.00
210402	Тээвэр, шатахуун	10,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000.00
2105	Нормативт зардал	21,446.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,308.94
210502	Хоол, хүнс	5,137.62
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,665.77
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,299.90
210604	Урсгал засвар	6,365.87
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83.96
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34.00
210807	Газрын төлбөр	49.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,655.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,655.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,513.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,513.60
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,113.60
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	87,777.06
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,777.06
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,777.06
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	812.49

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянтал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянтал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 12 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанаас 16 хоногоор хоцроож ирүүлсэн ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянтал сумын Эрүүл мэндийн төв нь Эмчилгээ үйлчилгээндээ улсын стандартыг мөрдөж, үйлчлэх хүрээний хүн амд сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх зорилт тавьж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянтал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 374,760.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,873.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1,499.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянтал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,992.1 мянган төгрөгөөр буюу 31.3 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр эздийн өмч дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		2,806.49	2,806.49
Авлага	1,739.69	135,361.11	133,621.42
Урьдчилгаа	3991.4	3991.4	0.00
Бараа материал	60,656.61	34,322.62	-26,333.99
Үндсэн хөрөнгө	377,200.57	406,098.77	28,898.19
Нийт хөрөнгө	443,588.27	582,580.38	138,992.12
Өр төлбөр	1,076.03	3,721.85	2,645.82
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	442,512.20	578,858.49	136,346.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	443,588.23	582,580.35	138,992.12

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,806.5 мянган төгрөг болж өссөн нь харилцах дансны үлдэгдлийг төрийн санд төвлөрүүлдэггүй болсонтой холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 133,621.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 халдварын эмчилгээний санхүүжилт 133,772.0 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34,322.6 мянган төгрөг болж 26,334.0 мянган төгрөгөөр буурсан бөгөөд нийт 21,142.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан нь голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 406,098.8 мянган төгрөг болж 28,898.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн эрүүл мэндийн газраас 34,165.9 мянга, сумын ОНХС-гаас 12,000.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого, 2,799.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч нийт 48,964.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 20,067.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл нэмэгдсэн нь цалингаас суутгасан нийгмийн даатгал болон хувь хүний орлогын албан татварыг шилжүүлээгүй 2,660.4 мянга, байгууллага болон хувь хүнд төлөх өр 1,061.4 мянга, нийт 3,721.8 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасанатай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 578,858.5 мянган төгрөг болж 136,346.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн байна.

Баянтал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 277,526.5 мянган төгрөгөөр буюу 67.2 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 62,011.6 мянга, нэмэлт санхүүжилт дансны орлого 210,191.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 179,346.1 мянган төгрөгөөр буюу 47.8 хувиар нэмэгдсэн байна. Үүнд: Цалин хөлс 41,371.0 мянга, НДШ 7,581.0 мянга, хангамж бараа материалын зардал 34,788.8 мянга, нормативт зардал 81,515.6 мянга, эд хогшил урсгал засварын зардал 2,026.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төслийн баримт материалыг архивлаж хадгалаагүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй тул аудитад хамрагдаагүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 347,839.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 347,839.9 төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 347,839.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, 339,498.3 мянган төгрөг зарцуулж, 6,347.6 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас дутуу санхүүжилт авсан тул зардал хэмнэгдэж, 1,994.0 мянган төгрөгийг үндсэн данснаас харилцахын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Хөтөлбөрийн код нэр	Арга хэмжээний код, нэр	Төлөв	Гүйц	Зөрүү
71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	80109-ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	49,037.60	49,037.60	0.00
	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	839.60	839.60	0.00
	81603-үндсэн мэргэжлийн тусламж үйлч	297,962.70	289,621.07	8,341.63
Нийт дүн		347,839.90	339,498.27	8,341.63

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд ЭМД-гаас сорьц тээвэр 548.6 мянга, ковид-19 вакцин 2,852.5 мянга, элэг бүтэн монгол хөтөлбөрөөс 406.0 мянга, ковид-19 хэвтэн эмчлүүлсний санхүүжилт 62,230.0 мянга, аймгийн ЭМГ-аас мөнгөн тэтгэмж 17,400.0 мянга, албан томилолтын зардалд 473.7 мянга, сургалтын зардалд 411.3 мянга, цайны зардал 200.0 мянга, эмч ажилчдын витаминжуулалт 455.0 мянга, Онцгой байдлын газар болон иргэн Сүрэнсугар нараас 1,800.0 мянга, аймгийн ЗДТГ-аас тэтгэмж 1,000.0 мянга нийт 87,777.1 мянган төгрөгийг хүлээн авч бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцолсон.

3.8 Аудитын гол асуудал

1. Завсрын болон өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлж ажиллаагүй. Санхүүгийн ажилтнууд 4 удаа солигдсоноос үндсэн хөрөнгө, бараа материалын тайланд хяналт тавьж баталгаажуулаагүй, ажил гүйлгээг гарсан тухай бүрд хөдөлгөөнийг бүртгээгүй, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж тайлагнасан. Бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл 2,722.4 мянга, орлого 7,273.6 мянга, зарлага 5,196.7 мянга, үлдэгдэл 4,799.7 мянга, нийт 19,992.8 мянган төгрөгөөр зөрүүтэй, байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 2,705.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан.
2. Ажиллагсад 40,922.0 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг бодож олгохдоо тухайн сарын төсөвт багтах дүнг тухайн сард нь олгож, дутуу олгосон илүү цагийн цалинг дараа сард олгох зэргээр нягтлан бодох бүртгэлийг аккурэл сууриар бус мөнгөн сууриар хөтөлсөн зөрчлүүд нь аудитын дүгнэлтийг өөрчлөх гол шалтгаан болсон.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянтал сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 116,906.7 мянган төгрөгийн 149 мэдээллийг байршуулахаас 73,883.2 мянган төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Баянтал сумын Эрүүл мэндийн төв нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг ирүүлээгүй, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын бараа материалын үлдэгдэл, цалин хөлсний бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаа тул дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай гэж үзсэн.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 115,053.7 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илэрснээс, 6,351.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 202.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 107,500.3 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 1,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэж ирүүлээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 3 дугаар зүйлийн 3.1, санхүүгийн тайлангийн толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул завсрын аудитаар залруулсан.
2. Санхүүгийн тайланг зэрэгцүүлэгдэхүйц байдлаар буюу өмнөх оны үзүүлэлтүүдийг тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 2 дугаар зүйлийн 2.1.11, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул завсрын аудитаар залруулсан.
3. Санхүүгийн үр дүнгийн тайланд зардлыг 3,312.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад залруулсан.
4. Санхүүгийн байдлын тайланд өр төлбөрийг 3,039.2 мянган төгрөгөөр илүү тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Хууль тогтоомжид тусгайлан зааснаас бусад тохиолдолд буюу байгууллагын дотоод журмыг үндэслэн олгосон тэтгэмжийн зардлаас ХХОАТ-ын 202.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20

дугаар зүйлийн 20.2.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 дах заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Завсрын болон өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. Жилийн санхүүгийн тайланд 3,721.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

2. Санхүүгийн ажилтнууд 4 удаа солигдсоноос үндсэн хөрөнгө, бараа материалын тайланд хяналт тавьж баталгаажуулаагүй, ажил гүйлгээг гарсан тухай бүрд хөдөлгөөнийг бүртгээгүй, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж тайлагнасан. Бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл 2,722.4 мянга, орлого 7,273.6 мянга, зарлага 5,196.7 мянга, үлдэгдэл 4,799.7 мянга, нийт 19,992.8 мянган төгрөгөөр зөрүүтэй, байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 2,705.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дах заалтуудыг зөрчсөн, УСНББОУС-1(15,16), УСНББОУС-12(476,49), санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1, 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

3. Ажиллагсад 40,922.0 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг бодож олгохдоо тухайн сарын төсөвт багтах дүнг тухайн сард нь олгож, илүү гарсан хэсгийг дараа сард олгох зэргээр нягтлан бодох бүртгэлийг аккурэл сууриар бус мөнгөн сууриар хөтөлсөн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 14 дүгээр зүйлийн 14.4.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС-1(7), УСНББОУС-33(29), санхүүгийн тайлангийн ангилал, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1, 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4. Цахим төлбөрийн системд хяналт тавьж ажиллаагүй. 3 иргэн, ААНБ-ын 3,356.0 мянган төгрөгийн худалдан авалт бичигдээгүй, 12 байгууллага 1,421.0 мянган төгрөгийн төлбөрийн баримт илүү бичигдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дах заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

5. ХХОАТ-ын тайланд 774.9 мянга, НДШ-ийн тайланд 1,374.9 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.3 дах заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

6. Шилэн дансны цахим хуудсанд 45 мэдээллийг хугацаа хоцроож, 37 мэдээллийг огт мэдээлээгүй. Төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 худалдан авалтын 37,038.1 мянга, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн 34,957.3 мянган төгрөгийн 5, хөрөнгө зарцуулах 1,887.9 мянган төгрөгийн 5 тушаал тус тус мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.5, 6.3.4, 6.3.5, 6.4.1, 6.4.2, 6.4.4, 6.4.5, 6.4.8, 6.10 дах заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ажиллагсдад олгосон 1,000.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтөөс нийгмийн даатгалын шимтгэл тооцож тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

Ажиллагсад олгож буй дэмжлэг, тусламж, шагнал урамшууллаас хууль тогтоомжийн дагуу суутган тооцож, шилжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянтал сумын ЭМТ	12	115,053.7	4	6,351.4	1	202.0	6	107,500.3	1	1,000.0